“Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

РАССЕЛ БЕДФОРД ИНТЕРНЭШНЛ
олон улсын сүлжээний гишүүн

2025.03.27 № 25/135

танай _____ -ны № _____-т

АУДИТОРЫН ТАЙЛАН

Хязгаарлалттай дүгнэлт

Бид Үндэсний хөрөнгө оруулалтын банк (“Компани”)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Энэхүү тайлангийн дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурьдсан асуудлын нөлөөнөөс бусдаар санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “*Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*” хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу банкнаас хараат бус байж, ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны аравдугаар сарын 30-ны өдрийн А-276 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаагүй хэвээр байна. 2024 оны жилийн эцсийн тайлангаар нийт өр төлбөр 462,375.9 мянган төгрөгөөр нэмэгдэж 176,307,650.41 мянган төгрөгт хүрсэнээр өөрийн хөрөнгийн хэмжээ (45,610,544.0) мянган төгрөг болсон байна.

Мөн Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны тавдугаар сарын 23-ны өдрийн А-138 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журамыг хангаагүй байна.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 хороо, Нарны зам-62, ЮНЕСКО-гийн гудамж,
Юнион билдинг Б блок, 14 давхарт, 1403 тоот

Утасны дугаар: +(976)-88880963, 80110088, 99005577
И-майл: shonkhor.mn@gmail.com
audit.rusbd@gmail.com

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.
- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх.
- Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэх талаар боломжит үндэслэлтэй баталгааг олж авах, түүнчлэн аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй нотолгоо нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч, АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй бүхий залилан ба алдааг бүрэн илэрхийлдэг гэсэн баталгаа биш юм.

Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг.

Бусад

Энэхүү дүгнэлтийг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн ба дүгнэлтийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

(Энэхүү дүгнэлт нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)

ЗАХИРАЛ Д.ШИЙРЭВ

BEDFORD
УЛААНБААТАР ХОТ
ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
9025010111 5821976 ШЖР1208
MEMBER
RUSSIAN INTERNATIONAL

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 хороо, Нарны зам-62, ЮНЕСКО-гийн гудамж,
Юнион билдинг Б блок, 14 давхарт, 1403 тоот

Утасны дугаар: +(976)-88880963, 80110088, 99005577
И-майл: shonkhor.mn@gmail.com
audit.rusbd@gmail.com

ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК
Санхүүгийн Байдлын Тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

	2024 мян.төг	2023 мян.төг
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	300,681.3	628,115.8
Хөрөнгө оруулалт	1,748,946.8	890,660.4
Зээл (цэвэр дүнгээр)	2,646,459.4	2,977,568.0
Бусад санхүүгийн хөрөнгө	180,857.1	(35,208.8)
Бусад санхүүгийн бус хөрөнгө	936,130.2	3,322,823,2
Үндсэн хөрөнгө	9,186,033.6	9,665,525.8
Борлуулах зориулалттай хөрөнгө	99,015,651.9	94,718,341.1
Биет бус хөрөнгө	16,682,346.1	16,746,928.6
Нийт хөрөнгийн дүн	**130,697,106.4**	**128,914,754.2**
ӨР ТӨЛБӨР		
Харилцах	152,303,723.0	144,412,772.3
Хадгаламж	2,629,538.0	9,777,802.4
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	3,927,039.4	6,051,282.0
Бусад эх үүсвэр	450,308.2	504,995.7
Бусад санхүүгийн өр төлбөр	11,584,088.6	10,839,839.4
Бусад санхүүгийн бус өр төлбөр	5,412,953.1	4,258,582.6
Нийт өр төлбөрийн дүн	**176,307,650.4**	**175,845,274.5**
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	50,130,000.6	50,130,000.6
Дахин үнэлгээний нэмэгдэл	4,260,124.7	4,260,124.7
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(100,000,669.3)	(101,320,645.7)
Өөрийн хөрөнгийн дүн	**(45,610,544.0)**	**(46,930,520.4)**
Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	**130,697,106.4**	**128,914,754.2**

RUSSELL INTERNATIONAL
ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
9025010111 6821978 ШЖР1208
MEMBER

ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК
Орлогын Дэлгэрэнгүй Тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

Үзүүлэлт	2024 мян.төг	2023 мян.төг
Хүүгийн орлого	1,149,927.9	16,189,474.2
Хүүгийн зардал	206,890.6	1,915,023.7
Цэвэр хүүгийн орлого	**943,037.3**	**14,274,450.5**
Эрсдэлийн сангийн зардал	490,777.9	15,905,976.3
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	**452,259.4**	**(1,631,525.7)**
Бусад орлого	67,435,723.2	115,793,824.6
Бусад зардал	66,568,006.3	100,628,252.6
Татварын өмнөх ашиг, алдагдал	**1,319,976.3**	**13,534,046.3**
Орлогын татварын зардал		969,563.3
Татварын дараах ашиг, алдагдал	**1,319,976.3**	**12,564,482.9**
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	**1,319,976.3**	**12,564,482.9**
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын	**1,319,976.3**	**12,564,482.9**

ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил (мян.төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт Дүн
2022 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	**50,130,000.6**			**4,260,124.7**		**(110,780,957.3)**	**(56,390,832.0)**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							
Залруулсан үлдэгдэл	50,130,000.6			4,260,124.7		(110,780,957.3)	(56,390,832.0)
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал						12,564,482.9	12,564,482.9
Өмчид гарсан өөрчлөлт						(3,104,171.3)	(3,104,171.3)
Хуваарилсан ногдол ашиг							
2023 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	**50,130,000.6**			**4,260,124.7**		**(101,320,645.7)**	**(46,930,520.4)**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							
Залруулсан үлдэгдэл	50,130,000.6			4,260,124.7		(110,780,957.3)	(56,390,832.0)
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал						1,319,976.3	1,319,976.3
2024 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	**50,130,000.6**			**4,260,124.7**		**(100,000,669.3)**	**(45,610,544.0)**

BEDFORD
УЛААНБААТАР ХОТ
RUSSELL
INTERNATIONAL
ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
9026010111 6821976 ШЖР1208
MEMBER

ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК
Мөнгөн Гүйлгээний Тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

Үзүүлэлт Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	2024 мян.төг	2023 мян.төг
Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	**1,319,976.3**	**13,534,046.3**
Орлого, зардлын тохируулга	**(6,148,932.1)**	**(29,517,856.5)**
Эрсдэлийн сангийн зардал	1,565,624.0	15,905,976.3
Элэгдэл, хорогдлын зардал	1,845,338.9	570,357.4
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого,зардал (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	(632,539.5)	(478,978.6)
Хуримтлуулсан хүүгийн орлого	(1,149,927.9)	(16,189,474.2)
Хуримтлуулсан хүүгийн зардал	206,890.6	1,915,023.7
Хөрөнгө данснаас хассаны олз, гарз	1,710,733.0	(143,756.7)
Бусад олз, гарз	(9,695,051.3)	(31,097,004.3)
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга	**15,231,478.8**	**17,583,793.6**
Зээлийн өсөлт, бууралт	3,783,592.8	16,093,936.1
Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт, бууралт	(216,065.9)	32,632.6
Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт, бууралт	10,188,569.0	(2,705,494.9)
Харилцах, хадгаламжийн өсөлт, бууралт	731,442.5	4,971,504.4
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт, бууралт	(2,124,242.6)	(926,647.5)
Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт, бууралт	744,249.1	(2,693,597.0)
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт, бууралт	2,123,933.8	2,811,459.7
Бусад тохируулга	**(11,589,590.9)**	**(8,947,616.3)**
Авсан хүү	1,149,927.9	16,189,474.2
Төлсөн хүү	293,256.9	(2,013,433.3)
Эрсдлийн сангаас хаасан олз, гарз	(27,849.4)	(27,849.4)
Бусад	(13,004,926.2)	(23,095,807.7)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	**(1,187,067.8)**	**454,243.1**

RUSSELL INTERNATIONAL
УЛААНБААТАР ХОТ
ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
9026010111 6621976 ШЖР1208
MEMBER

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	**11,600.0**	**5,000.0**
Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	11,600.0	5,000.0
Мөнгөн зарлагын дүн	**232,539.4**	**339,364.6**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	226,561.2	8,077.1
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,978.2	(347,441.7)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(220,939.4)**	**344,364.6**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн		
Мөнгөн зарлагын дүн	**54,687.5**	**(93,750.0)**
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**54,687.5**	**(93,750.0)**
Валютын ханшийн зөрүү	1,135,260.2	(462,388.2)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(327,434.5)**	**242,469.5**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**628,115.8**	**385,646.3**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**300,681.3**	**628,115.8**